



# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Булган аймгийн 2018 оны төсвийн тухай хуулийн  
хэрэгжилтийн явцад хийсэн санхүүгийн тайлан*



Булган хот  
2018 он

АУДИТЫН ТАЙЛАНГ  
БЭЛТГЭСЭН:Булган аймаг дахь  
Төрийн аудитын газарДарга, тэргүүлэх  
аудитор  
Д.АнхбаярАудитын менежер  
Ж.ЭнхцоодолАудитор  
А.Сувдаа  
Х.Баттулга2018 оны 10 дугаар  
сарУг тайланг аймгийн  
Төрийн аудитын  
газраас авч үзнэ үү:Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70342495, 70342716  
утасаар  
факс:70342580  
дугаараар харилцана  
уу

## ХАЯГ:

Булган сум 5-р баг  
Нутгийн удирдлагын  
ордон  
Өрөө № 403 тоот  
Bulgan@audit.gov.mnТовчилсон үгийн тайлбар..... 3  
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур  
үзүүлэлт.....4-6**Бүлэг 1. ....6-11**  
*Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг төлөвлөхдөө  
боломжит орлого бүрдүүлэх нөөцийг бүрэн дайчлах,  
зарцуулалтыг холбогдох хууль, эрх зүйн акттай бүрэн нийцсэн  
төсөл хөтөлбөрийг төлөвлөн батлах шаардлагатай байна.***Бүлэг 2.....11-14***Өссөн дүнгээр орлого 485.2 сая төгрөг буюу 1.2 хувиар давж  
биелэсэн ч 15 нэр төрлийн орлого тасарсан байна. Орлого  
давж биелэхэд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий ашиглах усны хэмжээ  
төлөвлөснөөс нэмэгдсэнтэй холбоотойгоор эерэг нөлөө  
үзүүлжээ.***Бүлэг 3.....14-19***Төсвийн хөрөнгөөр батлагдсан төсөл хөтөлбөр, арга хэмжээг  
санхүүжүүлэхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.1, 30.4.1 дэх  
заалтуудлыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, батлагдаагүй  
ажлыг Засаг даргын захирамжаар хэмнэлт үүссэн санхүүгийн  
эх үүсвэрээр тендерт шалгарсан компаниудтай нэмэлт гэрээ  
хийх эрх олгон хэрэгжүүлсэн байна.***Бүлэг 4.....19-24***ИТХ-аар батлагдсан зарим хөтөлбөр арга хэмжээний чанарын  
болон тооны үзүүлэлтийг үнэлж дүгнэх боломжгүй байна.  
Хобогдох журмын дагуу хөтөлбөр арга хэмжээнд эхний хагас  
жилийн байдлаар тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэгджээ.*

Дүгнэлт.....24-25

Зөвлөмж.....25-26

Хавсралтууд .....27-29

Судалгаа .....30-37

ТЭЗ-аас ирүүлсэн тайлбар.....38

Тайлан баталгаажуулсан тушаал .....39

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БХС	Байгаль хамгаалах сан
САГ	Санхүүгийн аудитын газар
СА	Санхүүгийн аудит
БУА	Булган аймаг дахь Төрийн аудитын газар
ААН	Аж ахуйн нэгж
ТББ	Төрийн бус байгууллаг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

### **1.Аудитын нэр:**

Аймгийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

### **2.Аудитын код:**

САГ-БУА-2018/02-СА

### **3.Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний 38 дахь заалтыг үндэслэн гүйцэтгэлээ.

### **4.Аудитын зорилт:**

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сан болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиудын хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, нэгдсэн дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит гүйцэтгэлээ. Үүнд:

- 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх,
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх,
- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх,
- ТЕЗ болон ТТЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх.

### **5.Аудитын хамрах хүрээ:**

Аудитыг аймгийн ТЕЗ, ТТЗ-дын 2018 оны 09 дүгээр сарын байдлаар санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

### **6.Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын болон Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**7.Аудитад ашиглах хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт:**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Ирээдүйн өв сангийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- Аймгийн ИТХ-ын тогтоол
- Бусад холбогдох бусад хууль, тогтоомж, журам, зааврууд

**8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдан, менежер Ж.Энхцоодол ахалж, аудитор А.Сувдаа, Х.Баттулга нар 2018 оны 09 дүгээр сарын 03-аас төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

**9.Үндсэн мэдээлэл:**

Аймгийн ИТХ-ын 06 дугаар хуралдааны 06 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар “ТЭЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт”, 2 дугаар хавсралтаар “Аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын, төсөл арга хэмжээний жагсаалт”, 3 дугаар хавсралтаар “Аймгийн 2018 оны авто сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт”, 4 дүгээр хавсралтаар “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт”, 5 дугаар хавсралтаар “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хуваарилалт”-ыг тус тус баталсан байна.

Аймгийн 2018 оны төсвийн нийт орлогыг 54169.4, нийт зардлыг 54169.4 сая төгрөг, энэ жил улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийг 0.0 сая төгрөгөөр тогтоожээ.

## Төрийн Аудитын газар

**Бүлэг 1**

*Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг төлөвлөхдөө боломжит орлого бүрдүүлэх нөөцийг бүрэн дайчлах, зарцуулалтыг холбогдох хууль, эрх зүйн акттай бүрэн нийцсэн төсөл хөтөлбөрийг төлөвлөн батлах шаардлагатай байна.*

**1.1.**Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх зарчмуудыг баримтална. Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага болох төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүргийн дагуу Төсвийн тухай хуулийн 8.5.1-д “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасны дагуу төсвийн төслийг боловсруулж 2017 оны 11 дүгээр сарын 24-ний 03/1469 тоот албан бичгээр аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

Аймгийн СТСХ нь 2018 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоол зэргийг баримтлан боловсруулж аймгийн 2018 оны төсөв нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийг мөрдөж, хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж татварыг 10-25 хувь болгож тайлант оны эхнээс мөрдөгдөж эхлэх, татварын хөнгөлөлтийн хэмжээг 120.0 мянган төгрөг болгон өөрчилсөн зэрэг тооцооллыг хийж боловсруулсан байна. Аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан бүтээн байгуулалт болон Засаг даргын нөөцийн хөрөнгө, хөтөлбөр арга хэмжээний зардлыг бууруулахгүй байхыг зориж ажилласан байна.

Аймгийн ИТХ 2018 оны төсвийн төслийг хэлэлцэн мөн хуулийн 8.5.2-т заасны дагуу 2017 оны 12 дугаар сарын 05-ны 06 дугаар хуралдааны “Булган аймгийн 2018 оны төсвийг батлах тухай” 06 дугаар тогтоолоор аймгийн татварын болон татварын бус, хөрөнгө оруулалтын орлогыг 18436.6, ОНХС-д олгох шилжүүлгийн орлогыг 2312.2, тусгай зориулалтын шилжүүлэгт 30594.4, урьд оны үлдэгдэл 2826.1 сая төгрөгийн эх үүсвэртэйгээр нийт 54169.4 сая төгрөгийг зарцуулахаар Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан загвар маягтын дагуу баталжээ. Энэ онд улсын төсөвт төвлөрүүлэх шийлжүүлгийг тусгаж өгөөгүй байна.

Уг тогтоолын 1 дүгээр хавсралтаар “ТЕЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт”-ээр 21 үзүүлэлтийн хүрээнд зорилт дэвшүүлж, 2 дугаар хавсралтаар “Аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын, төсөл арга хэмжээний жагсаалт”-аар 22 төсөл арга хэмжээнд 2713.2, 3 дугаар хавсралтаар “Аймгийн 2018 оны авто сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт”-аар 10 төсөл, арга хэмжээнд 391.6, 4 дүгээр хавсралтаар “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт”-аар 17 хөтөлбөр арга хэмжээнд 72.9, 5 дугаар хавсралтаар “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хуваарилалт”-аар 75 төсөл, арга хэмжээнд 4641.3 нийт 124 хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 7819.0 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.



1.2.Аймгийн 2018 оны төсвийг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмуудад үндэслэн боловсруулж нийт орлого, зарлагыг 56.3 тэрбум төгрөгөөр төсөвлөж өмнөх оноос 4.3 тэрбум төгрөгөөр өсгөсөн байна.

Орон нутгийн 2018 оны суурь орлого болон зардлыг УИХ, СТСХ-ийн төлөвлөсөн дүнг 3512.7 сая төгрөгөөр бууруулж, СТСХ өмнөх оны тодотгосон дүнгээс 1113.3, УИХ-аар баталсан дүнгээс СТСХ 3511.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж 23299.2 сая төгрөгөөр төсвийг боловсруулжээ. Аймгийн 2018 оны нийт зардлыг УИХ, СТСХ-ийн төлөвлөсөн дүнг 3511.7 сая төгрөгөөр бууруулж, СТСХ өмнөх оны тодотгосон дүнгээс 3511.1, УИХ-аар баталсан дүнгээс СТСХ 5825.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 56205.8 сая төгрөгөөр төлөвлөж орон нутгийн байгууллагуудад 23299.2, тусгай зориулалтын шилжүүлэгт 30594.4, орон нутгийн хөгжлийн санд 2312.2 сая төгрөгийг хуваарилахаар төлөвлөжээ.

Уг төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.4 дэх “Орон нутгийн төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж аймаг нийслэлийн ИТХ-д оруулах” гэж заасны дагуу манай байгууллагаас нэмэлтээр холбогдох тооцоолол, судалгааг хийн нийт 2973.7 сая төгрөгийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, 924.8 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх санал хүргүүлсэн. Саналын зарим төсөл хөтөлбөр арга хэмжээг үр ашиг дээшлүүлэх буюу зардал бууруулах саналыг харгалзан үзэлгүйгээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.4, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заагдаагүй төсөл хөтөлбөр, ОНХС-гийн хөрөнгийн зарцуулах журмын 4.4 дэх заалт, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын дагуу төсөв захирагч нарт хүргүүлсэн Засгийн газрын чиглэлийн 1.2 дахь заалтын “в, д” дахь заалт, харьцуулсан тооцоо судалгааг үндэслэл болгож мөрдөөгүй байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тооцож үзэхэд ус ашигласны төлбөрийн орлогоос байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх “Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар” -ын дагуу дараах хувь хэмжээгээр нөхөн сэргээлт хийхээр хуульчилжээ.

Байгалийн нөөцийг нөхөн сэргээх хувь хэмжээ

/сая.төг/

№	Орлогын төрөл	Жилийн батлагдсан орлогын дүн	Байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулахаар батлагдсан дүн	Орлогын хувь, хэмжээний доод хязгаар	Хуулийн дагуу нөхөн сэргээхэд зарцуулах дүн	Зөрүү /Илүү (дутуу)/
1	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	28.7	23	15%	4.3	18.7
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	21.7	23	50%	10.9	12.2
3	Газрын нөөцийн төлбөрийн орлого	289.5	998.8	15%	43.4	955.4

4	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	300.8	1499.8	85%	255.7	1244.1
5	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	13242.4	1430.9	35%	4634.8	-3203.9
<b>Дүн</b>		<b>13883.1</b>	<b>3975.5</b>	<b>200%</b>	<b>4949.1</b>	<b>-973.6</b>

Дээрхи хүснэгтээс харахад ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулж буй мөнгөн дүн хуульчилсан хувь хэмжээнд хүрэхгүй байна. Өөрөөр хэлбэл Усны нөөцийг нөхөн сэргээхэд орлогын 10.8 хувийг зарцуулахаар буюу 24.2 хувиар дутуу, бусад байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд хуулиар заагдсан хувь хэмжээнээс 56-413.6 хувиар давсан дүнгээр зарцуулалт хийхээр төсөвлөсөн байгаа нь нөхөн сэрээлтийг бодиттой төлөвлөөгүй, дутуу зарцуулж буй дүнгээс бусад нөхөн сэрээлт болон төсөл хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлжээ.

Эхний есөн сарын байдлаар нийт орлого 485.2 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар давж биелэсэн нь өмнөх оны мөн үеэс 2298.2 сая төгрөг буюу 5.8 хувиар өссөн байна.

### Орлогын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл

/сая.төг/

Үзүүлэлт	Өссөн сарын дүнгээрх төлөвлөгөө	Өссөн сарын дүнгээрх гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>41,140.74</b>	<b>41,625.93</b>	<b>485.19</b>	<b>101.2%</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	14,460.22	15,750.21	1289.99	108.9%
Орлогын албан татвар	3,331.26	2,885.82	-445.44	86.6%
Хувь хүний орлогын албан татвар	3,851.26	3,438.98	-412.28	89.3%
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	3,060.00	2,609.28	-450.72	85.3%
Үйл ажиллагааны орлого	118.56	66.17	-52.40	55.8%
Хөрөнгийн орлого	285.41	348.88	63.47	122.2%
Шууд бус орлого	387.29	414.65	27.36	107.1%
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-520.00	-553.16	-33.16	106.4%
Хөрөнгийн албан татвар	563.37	554.87	-8.51	98.5%
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	305.00	257.68	-47.32	84.5%
Бууны албан татвар	38.49	24.05	-14.45	62.5%
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	219.88	273.14	53.26	124.2%
Бусад татвар, төлбөр, хураамж	10,565.60	12,309.52	1743.93	116.5%
Бусад нийтлэг төлбөр, хураамж	260.48	250.98	-9.51	96.4%
Улсын тэмдэгтийн хураамж	135.00	125.42	-9.59	92.9%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	24.91	53.69	28.78	215.5%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	89.95	69.21	-20.75	76.9%



Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	9.86	2.00	-7.86	20.3%
Бусад татвар	0.75	0.66	-0.09	88.4%
Газрын төлбөр	204.00	139.65	-64.35	68.5%
Газрын төлбөр	129.00	139.65	10.65	108.3%
Дуудлага худалдаа	75.00	0.00	-75.00	0.0%
Байгалийн нөөц ашигласны төлбөр	10,101.11	11,917.96	1816.85	118.0%
Ойн нөөц ашигласны төлбөр	141.90	132.92	-8.98	93.7%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	19.07	13.39	-5.68	70.2%
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	9,938.93	11,768.32	1829.39	118.4%
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.22	3.33	2.11	273.1%
Бусад татвар	0.00	0.94	0.94	
Бусад татвар	0.00	0.93	0.93	
Нохойны албан татвар	0.00	0.01	0.01	
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>26,680.52</b>	<b>25,875.72</b>	<b>-804.79</b>	<b>97.0%</b>
Нийтлэг татварын бус орлого	2,777.30	2,009.73	-767.57	72.4%
Хувьцааны ногдол ашиг	0.00	0.00	0.00	
Хүүгийн орлого	333.15	15.00	-318.15	4.5%
Торгуулийн орлого	0.00	348.19	348.19	
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,398.32	1,585.10	-813.23	66.1%
Түрээсийн орлого	23.87	17.58	-6.28	73.7%
Бусад орлого	21.97	43.86	21.90	199.7%
Хөрөнгийн орлого	16.50	24.56	8.06	148.9%
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	16.50	24.56	8.06	148.9%
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	23,886.72	23,841.43	-45.29	99.8%
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	22,128.04	22,117.75	-10.29	100.0%
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,758.68	1,723.69	-34.99	98.0%

Орлогыг нэр төрлөөр үзвэл жигд ханган биелүүлээгүй буюу 10 нэр төрлийн орлого 2041.9 сая төгрөгөөр давж, 14 нэр төрлийн орлого 1557.6 сая төгрөгөөр тасарсан бол төлөвлөгдөөгүй нохойны албан татвар болон бусад татварын 0.9 сая төгрөгийн орлого оржээ.

Орлогын албан татвар тайлант үеийн өссөн дүнгээр 14460.2 сая төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 15750.2 сая төгрөг төвлөрч 1289.9 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Давуулан биелүүлэхэд Хөрөнгийн орлого 63.5, шууд бус орлого 27.4, хувь хүний орлогын албан татварын буцаалт 33.2, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 53.3, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 28.8, ус рашааны нөөц ашигласны төлбөр 1819.4, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 2.1 сая төгрөгөөр давж биелсэн нь орлогыг бодиттой төлөвлөөгүйг илэрхийлж байна.

Усны төлбөр нийт дүнгээр биелж байгаа ч уул уурхайгаас орох усны төлбөрийг дутуу төлөвлөсөн байна. Тухайлбал: “Их тохойрол” ХХК 20.0, “Тэргүүн

майнинг” ХХК 10.0 сая төгрөг зэрэг төсөвт төлөвлөөгүй нийт 38.9 сая төгрөгийн орлого оржээ. /Дэлгэрээгүйг хүснэгт 1-ээс харах/

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 24.9 сая төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 53.7 сая төгрөг буюу 215.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

**Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн биелэлтийг сумдаар авч үзвэл:**

/ мян.төг/

№	Сумд	Батлагдсан төсөв	Төсөв /Өссөн дүнгээрх/	Гүйцэтгэл /Өссөн дүнгээрх/	Зөрүү	Биелэлт
1	Баян-Агт	200	140.0	0	(140.0)	0.0%
2	Баяннуур	3300	1,600.0	1111.9	(488.1)	69.5%
3	Бугат	6200	5,000.0	0	(5,000.0)	0.0%
4	Булган сум	2000	2,000.0	1726.9	(273.1)	86.3%
5	Бүрэгхангай	3200	2,000.0	70	(1,930.0)	3.5%
6	Гурванбулаг	600	600.0	483.9	(116.1)	80.7%
7	Дашинчилэн	1500	1,125.0	3856.5	2,731.5	<b>342.8%</b>
8	Могод	200	200.0	200	-	100.0%
9	Орхон	4700	3,600.0	10451.4	<b>6,851.4</b>	<b>290.3%</b>
10	Сайхан	500	300.0	610	310.0	<b>203.3%</b>
11	Сэлэнгэ	2500	1,650.0	0	(1,650.0)	0.0%
12	Хангал	5600	4,199.4	32600.8	<b>28,401.4</b>	<b>776.3%</b>
13	Хишиг-Өндөр	1000	-	0	-	
14	Хутаг-Өндөр	3000	2,500.0	2580.2	80.2	103.2%
<b>Нийт дүн</b>		<b>34500</b>	<b>24914.4</b>	<b>53691.6</b>	<b>28,777.2</b>	<b>215.5%</b>

Дээрх хүснэгтээс харахад Хангал сумын Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 5600.0 мянган төгрөгөөр төлөвлөж биелэлт 32534.8 мянган төгрөг буюу 581.0 хувийн биелэлттэй байгааг өмнөх 2 жилийн гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд тухайн татварын бус орлогын төлөвлөлтийг маш багаар баталж тодотголоор 6-8 дахин их дүнгээр өөрчлөн баталж байгаа нь гүйцэтгэлд суурилан орлогыг боломжит түвшинд нөөцийг бүрэн дайчилж төлөвлөдөггүй байна. Энэ талаар тодруулахад “Эрдэнэт үйлдвэр”-ээс хайрга ашигласан тохиолдолд тухайн орлогын биелэлт өндөр байдаг, хэрэв тус үйлдвэр сумаас хайрга бэлтгэхгүй бол орлогын эх үүсвэр бүрдэхгүй орлого тасрах хүндрэл учрах тул гүйцэтгэлээр төлөвлөгөө баталдаггүй, бодит гүйцэтгэлийг үндэслэн тодотголоор нэмж батлуулж ажиллаж байна” гэсэн тайлбарыг тус сумын татварын байцаагч өгсөн болно.

Нийт зардлыг 59850.2 сая төгрөгөөр баталж эхний 9 сарын өссөн дүнгээр 46598.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 39528.0 сая төгрөг зарцуулж 7070.9 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнажээ.

Тайлант оны өссөн дүнгээр нийт зардлаас таван нэр төрлийн зардал 18.1-46.0 хувийн зарцуулалттай байна. Гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Төсөв /өссөн дүнгээрх/	Гүйцэтгэл /өссөн дүнгээрх/	Гүйцэтгэлийн хувь
1	Гадаад албан томилолт	60,000.0	60,000.0	16,800.6	28.0%
2	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,832.5	8,832.5	2,848.6	32.3%
3	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450.0	450.0	198.0	44.0%
4	Газрын төлбөр	1,249.9	1,151.3	208.6	18.1%
5	Эргэж төлөгдөх зээл	2,844,249.8	2,534,350.2	1,165,164.4	46.0%

Хуваарийн дагуу зарцуулалт хийгдээгүй шалтгааныг тодруулахад аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардлыг бүх төсөвт байгууллагууд төсөвлөдөг бөгөөд ихэнх байгууллага түүвэрт хамрагддаг, түүвэрт хамрагдсан байгууллага аудитын баталгаажуулалтын төлбөр төлдөггүйгээс хэмнэгдсэн бол бусад зарцуулалт нь жилдээ зарцуулагдахаар байна гэсэн тайлбар өглөө. Үүнээс үзэхэд нэг удаагийн биш зардлыг зарцуулах хуваарийг оновчтой төлөвлөөгүйгээс сарын өссөн дүнгээрх гүйцэтгэл хэмнэлт үүсгэж байна.

Нийт дүнгээр хэтрэлт үүссэн зарцуулалт байхгүй ч төсөвт 68 байгууллага цалин, гэрэл цахилгаан, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбооны зэрэг нийтлэг зардлыг хэтрүүлэн бүлэг дотор шилжүүлэн зарцуулжээ. Төсвийг оновчтой, тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүйгээс зардлын ангилалд хэтрэлт үүссэн байна.

1.3.Тайлант оны санхүүгийн эх үүсвэрийг 2016 оны гүйцэтгэлээс 2023.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бол 2017 оны гүйцэтгэлээс 577.3 сая төгрөгөөр бууруулан баталсан байна. Эх үүсвэрийг хураангуйлан хүснэгтээр харвал:

### Эх үүсвэрийн харьцуулалт

/сая.төг/

ОРЛОГЫН ТӨРӨЛ	2016 он	2017 он	2018 он	Батлагдсан төсвийн өөрчлөлт			
	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	2016 оны гүйцэтгэлээс	2017 оны гүйцэтгэлээс	Төсвийн төслөөс
НИЙТ ОРЛОГО	18,738.0	21,338.8	20,473.0	20,761.5	2,023.5	(577.28)	288.51
УРСГАЛ ОРЛОГО	18,726.3	21,290.0	20,451.0	20,739.5	2,013.2	(550.51)	288.51
ТАТВАРЫН ОРЛОГО	17,844.6	20,502.5	19,665.1	19,904.0	2,059.4	(598.49)	238.91
Орлогын албан татвар	4,119.8	4,595.2	4,930.7	4,937.2	817.4	342.00	6.50
Өмчийн татвар	417.2	446.6	468.5	467.1	49.9	20.54	(1.39)
Бараа, үйлчилгээний татвар	257.2	272.5	260.0	260.0	2.8	(12.51)	-
Бусад татвар	13,050.4	15,188.2	14,005.9	14,239.7	1,189.3	(948.52)	233.80
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	881.7	787.5	785.9	835.5	(46.2)	47.99	49.60

ХӨРӨНГИЙН ОРЛОГО	11.7	48.8	22.0	22.0	10.3	(26.78)	-
---------------------	------	------	------	------	------	---------	---

Орлогын тооцооллыг гол төлөв өмнөх он, онуудын гүйцэтгэл, хууль эрх зүйн өөрчлөлтөнд үндэслэн эх үүсвэрийн дүнг төсвийн төслөөр 20473.0 сая төгрөгөөр тооцжээ. Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нийт санхүүгийн эх үүсвэр болох нийт орлогыг 20761.5 сая төгрөг болгон баталсан байна.

## Төрийн Аудитын газар

## Бүлэг 2

*Энхий 9-н сарын өссөн дүнгээр орлого 485.2 сая төгрөг буюу 1.2 хувиар давж биелэсэн ч 15 нэр төрлийн орлого тасаржээ. Орлого давж биелэхэд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий ашиглах усны хэмжээ төлөвлөснөөс нэмэгдсэнтэй холбоотойгоор эерэг нөлөө үзүүлжээ.*

2.1.Аймгийн нийт орлогын эх үүсвэрийг 20530.6 сая төгрөгөөр баталсан хүлээгдэж буй гүйцэтгэлээр 21703.7 сая төгрөг буюу 5.7 хувиар давж биелэхээр тооцоолжээ.

## Батлагдсан болон хүлээгдэж буй гүйцэтгэлээрх орлого

/сая.төг/

ОРЛОГЫН ТӨРӨЛ	Батлагдсан төсөв		Хүлээгдэж буй гүйцэтгэл		Батлагдсан төсөв ХБГ-ээрх	
	Мөнгөн дүн	Эзлэх хувийн жин	Мөнгөн дүн	Эзлэх хувийн жин	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ОРЛОГО</b>	20,761.5	100%	21,703.7	100%	942.15	104.5%
<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	20,739.5	99.9%	21,679.3	104.4%	939.73	104.5%
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	19,904.0	95.9%	21,076.8	101.5%	1,172.84	105.9%
Орлогын албан татвар	4,937.2	23.8%	4,735.8	22.8%	(201.37)	95.9%
Хувь хүний орлогын албан татвар	5,457.2	26.3%	5,289.0	25.5%	(168.21)	96.9%
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	4,247.0	20.5%	4,084.8	19.7%	(162.23)	96.2%
Үйл ажиллагааны орлого	201.7	1.0%	198.1	1.0%	(3.64)	98.2%
Хөрөнгийн орлого	392.5	1.9%	399.0	1.9%	6.52	101.7%
Шууд бус орлого	616.0	3.0%	607.1	2.9%	(8.86)	98.6%
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	520.0	2.5%	553.2	2.7%	33.16	106.4%
Өмчийн татвар	467.1	2.2%	458.5	2.2%	(8.58)	98.2%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	403.2	1.9%	395.6	1.9%	(7.60)	98.1%
Бууны албан татвар	63.9	0.3%	62.9	0.3%	(0.98)	98.5%
Бараа, үйлчилгээний татвар	260.0	1.3%	260.0	1.3%	-	100.0%
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татвар	260.0	1.3%	260.0	1.3%	-	100.0%
Бусад татвар	14,239.7	68.6%	15,622.5	75.2%	1,382.79	109.7%
Улсын тэмдэгтийн хураамж	191.5	0.9%	188.4	0.9%	(3.10)	98.4%
Газрын төлбөр	289.5	1.4%	289.5	1.4%	-	100.0%
Үүнээс: Газрын төлбөр	189.5	0.9%	189.5	0.9%	-	100.0%

Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт	100.0	0.5%	100.0	0.5%	-	100.0%
Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	300.8	1.4%	298.1	1.4%	(2.70)	99.1%
Ан амьтан барих эрхийн зөвшөөрлийн хураамж	21.7	0.1%	22.9	0.1%	1.21	105.6%
Бусад татвар хураамж	13,436.3	64.7%	14,823.7	71.4%	1,387.38	110.3%
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг	28.7	0.1%	28.7	0.1%	-	100.0%
Ус ашигласны төлбөр	13,242.4	63.8%	14,647.2	70.5%	1,404.80	110.6%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	34.5	0.2%	29.4	0.1%	(5.12)	85.2%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	130.7	0.6%	118.4	0.6%	(12.30)	90.6%
Бусад татвар	1.0	0.0%	1.0	0.0%	-	100.0%
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>835.5</b>	<b>4.0%</b>	<b>602.4</b>	<b>2.9%</b>	<b>(233.11)</b>	<b>72.1%</b>
Хувьцааны ногдол ашиг	16.0	0.1%	16.0	0.1%	-	100.0%
Хүү торгуулийн орлого	441.4	2.1%	431.5	2.1%	(10.00)	97.7%
Төсвийн байгууллагын өөрийн орлого	313.8	1.5%	313.8	1.5%	-	100.0%
Түрээсийн орлого	33.8	0.2%	33.8	0.2%	-	100.0%
Нэр заагдаагүй бусад орлого	30.5	0.1%	43.3	0.2%	12.80	142.0%
<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>22.0</b>	<b>0.1%</b>	<b>24.4</b>	<b>0.1%</b>	<b>2.41</b>	<b>111.0%</b>
Хөрөнгө борлуулсаны орлого	22.0	0.1%	24.4	0.1%	2.41	111.0%

Аймгийн нийт орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр давж биелэхээр байгаа ч нэр төрлөөр тасрах магадлалтай байна. Өндөр дүнтэй орлого төлөвлөсөн дүнгээс давхаар байгаа нь төсвийн алдагдал үүсэх эрсдэлийг бууруулж эерэг нөлөө үзүүлж байгаа боловч нөгөө талаар төлөвлөлтийн тооцоолол үнэн бодит хийгдээгүйгээс зарим нэр төрлийн орлого тасрах, цөөн нэр төрлийн орлого давж биелэхээр харагдаж байна.

Ихэнх орлогын эх үүсвэрийг дээр дурьдсаны адил гүйцэтгэлд үндэслэн тооцоолсон нь орлогын нөөцийг бүрэн хамруулсан үндэслэл болж чадахгүй байна. Тухайлбал: Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг өмнөх 5 жилийн гүйцэтгэлд үндэслэн 400.0 сая төгрөгөөр төсөвлөж, 403.2 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оноос 4.7 хувиар нэмэгдүүлжээ. Гэвч аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн 2018 оны 1/351 тоотын хавсралт судалгаагаар нийт 426.2 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгдөхөөр бүртгэгдсэн нь тайлант онд 23.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломж байсан байна. Төсөв боловсруулахдаа шаардлагатай мэдээллийг цуглуулж, холбогдох судалгаа, шинжилгээ, тооцооллыг бүрэн хийгээгүйгээс орлого бүрдэх нөөц боломжийг алдсан байна.

Хүснэгтээс үзэхэд хэдийгээр нийт орлого давж төлөвлөгөөт орлого биелэх боломжтой ч нэр төрлөөр тасрахаар байна. Өөрөөр хэлбэл татварын 18 нэр төрлийн орлогоос 5, татварын бус 5 нэр төрлийн орлогоос 1, хөрөнгийн орлого буюу нийт 7 нэр төрлийн орлого давж, 6 нэр төрлийн орлого бүрэн биелэж 11 нэр төрлийн орлого тасрахаар тооцоолол гарсан байна. Хэдийгээр тасарч буй орлогын нэр төрөл их ч дүнгийн хувьд бага, ус ашигласны төлбөр нэмэгдэж буйгаас нийт орлого биелэхэд эерэг нөлөөлөл үзүүлжээ. Батлагдсан төсвийн 64.5 хувийг уг орлого эзэлсэн бол хүлээгдэж буй гүйцэтгэлээрх нийт дүнгийн 71.3 хувийг бүрдүүлэхээр байна. Ус ашигласны төлбөр төлөвлөснөөс 1404.8 сая төгрөгөөр давж биелэхээр байгаа нь төлөвлөгөө боловсруулахдаа 2017 оны гүйцэтгэл болон тус үйлдвэрээс

санал авч боловсруулдаг ч бодит ус ашиглах гэрээ тайлант онд хийгддэг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий 2018 онд ашиглах усны хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1

**Аж ахуйн нэгжийн ус ашигласны татварын орлогыг  
төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мян.төг/

Д/д	ААН-ийн нэр	2017 он			2018 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Өгөөж баян хангай	31.6	24.7	-6.9	24	10.2	-13.8
2	Хүслэмж	4.7		-4.7			0
3	ГБНБ	73.6	54	-19.6			0
4	Монполимет	450	107.3	-342.7	107	100	-7
5	Хосхас	36.9	33.4	-3.5	33.4	29.7	-3.7
7	Хамтын эх булаг	18.1	5.7	-12.4	5.7	5	-0.7
8	Шарнарст	8		-8	8		-8
9	Эрдэнэт үйлдвэр	11100	13550	2450	12723.6	11500	-1223.6
10	ЭДЦС	70	80.8	10.8	75	58.5	-16.5
11	Заамар гоалд		2.8	2.8			0
12	Ориент майнинг инвестмент		7.2	7.2	23.3		-23.3
13	Баянгол эко заамар		7	7			0
14	Эко алтан заамар		30.3	30.3		20	20
15	Төсөлч		8	8		3.8	3.8
16	Цагаан уулын магнит		30.9	30.9			0
17	Тэргүүн майнинг		0.4	0.4		10	10
18	Наран Гоулд ХХК					5	5
19	Од төл ХХК					0.06	0.06
<b>Нийт</b>		<b>11793.0</b>	<b>13943.0</b>	<b>2149.6</b>	<b>13000.0</b>	<b>11742.0</b>	<b>-1257.7</b>

Өмнөх оны төлөвлөгөө гүйцэтгэлээр нийт 6 аж ахуй нэгжийн 397.8 сая төгрөгийн ус, рашаан ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлсэнг авлагаар бүртгэж тайлагнаагүйд хугацаатай төлбөрийн акт тогтоолоо.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр зарим нэр төрлийн орлого бүрэн биелэхгүй гэж үзсэн нь учир дутагдалтай байна. Жишээ нь: ХЗДХС-ын 2018 оны А/33, А/184 дугаар тушаалаар “Бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах журам”-д өөрчлөлт оруулсантай холбогдуулж зөрчил гаргасан жолоочид зохих торгуулийг оногдуулж байгаа ч ихэнх жолооч бэлэн бус торгуулийн хуудсанд заагдсан хугацаанд торгуулийг төлөхгүйгээс тус орлогын биелэлт хангалтгүй байна. Журмын 4.1-д заасны дагуу торгуулийг барагдуулснаар орлого төвлөрөх боломжтой ч журмын 4.2-т заагдсан төлүүлэх арга хэмжээ авах ажлыг Цагдаагийн байгууллагаас оновчтой зохион байгуулаагүйтэй холбоотой байна.

**2.2.Төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын төсөвт төвлөрүүлэх орлогыг гүйцэтгэлээр авч үзвэл дараах байдалтай байна.**



## Орлого төвлөрүүлэх байдлаар авч үзвэл

/сая.төг/

№	Орлогын төрөл	2016 он		2017 он		2018 он					
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Төл /өссөн дүнгээр/	Гүйц /өссөн дүнгээр/	Гүйцэтгэлийн хувь	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Зөрүү
1	ОНӨ ногдох хувьцааны ногдол ашгийн орлого	35	40	13.2	38.4	16	0	0	0.0%	16	0
2	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	34	11.7	20	48.8	22	16.5	24.4	147.9%	24.4	2.4
3	Төсөвт байгууллагын орлого	194.1	452.2	265	152.4	313.9	227.9	210.6	92.4%	313.9	0
<b>Нийт</b>		<b>263.1</b>	<b>503.9</b>	<b>298.2</b>	<b>239.6</b>	<b>351.9</b>	<b>244.4</b>	<b>235.0</b>	<b>96.2</b>	<b>354.3</b>	<b>2.4</b>

Төсөвт орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагаас энэ онд 16.0 сая төгрөгийн ногдол ашгийн орлогыг төвлөрүүлэх боломжтой гэж үзэн аймгийн ИТХ-аар баталжээ. Орлогын хуваарийн дагуу 12 дугаар сард төвлөрөхөөр хүлээгдэж байна.

Хөрөнгө борлуулсны орлого давж биелсэн нь энэ онд дуудлага худалдаагаар борлуулахаар төлөвлөсөн орон нутгийн өмчийн автомашин, болон бусад хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

## Төрийн Аудитын газар

## Бүлэг 3

*Төсвийн хөрөнгөөр батлагдсан төсөл хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.1, 30.4.1 дэх заалтуудлыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, батлагдаагүй ажлыг Засаг даргын захирамжаар хэмнэлт үүссэн санхүүгийн эх үүсвэрээр тендерт шалгарсан компаниудтай нэмэлт гэрээ хийх эрх олгон хэрэгжүүлсэн байна.*

**3.1.** Тайлант оны төсвийн орлогыг 59850.2 сая, зардлыг 59850.2 сая төгрөгөөр өмнөх оны гүйцэтгэлээс 11 хувиар өсгөж баталсан байна.

Төсвийн зардал 9 дүгээр сарын гүйцэтгэлээр 39531.8 сая төгрөг буюу 84.8 гүйцэтгэлтэй үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал 19096.3 сая буюу 78.4 хувь, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зардал 20435.5 сая буюу 91.8 хувь байна.

Сумдын ОНХС-д Сангийн яамнаас 580.1 сая төгрөгийг шилжүүлсэн аймгийн Авто замын сан 286.9 сая буюу 75.4 хувь, Байгаль хамгаалах сан 2528.6 сая буюу 57.0 хувь, аймгийн орон нутгийн хөгжлийн сан 512.9 сая буюу 67.9 хувь, орон нутгийн хөрөнгө оруулалт 2391.7 сая төгрөг буюу 88.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Авлага, өглөгийг Сайдын багцаар авч үзвэл Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын байгууллагууд 171.2, Эрүүл мэндийн сайдын байгууллагууд 57.3, орон нутгийн байгууллагууд 113.2 сая төгрөгийн өртэй байна.

/сая.төг/

Сайдын багцаар	АВЛАГА			ӨГЛӨГ		
	Өмнөх оны мөн үеийн үлдэгдэл	9-р сарын эхний үлдэгдэл	9-р сарын эцсийн үлдэгдэл	Өмнөх оны мөн үеийн үлдэгдэл	9-р сарын эхний үлдэгдэл	9-р сарын эцсийн үлдэгдэл
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	0.1	0.7	0.7	45.1	179.5	171.2
Орон нутгийн засаг захиргаа	47.5	0.8	2.1	142.5	118.9	113.2
Эрүүл мэндийн сайд	0.0	0.0	0.0	40.2	67.9	57.3
Тэтгэвэрийн даатгал	0.0	0.1	0.1	0.0	0.0	0.0
<b>НИЙТ</b>	<b>47.6</b>	<b>1.6</b>	<b>2.9</b>	<b>227.8</b>	<b>366.2</b>	<b>341.7</b>

Нийт өглөг 341.7 сая, нийт авлага 2.8 сая, өглөг өмнөх сараас 24.5 сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үетэй харьцуулбал 113.9 сая төгрөгөөр өссөн үүнээс цалин НДШ-ийн өглөг 92.1, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өглөг 171.8, эмийн өглөг 36.7, бусад зардлын өглөг 41.1 сая төгрөг байна.

### Төсвийн зардлын гүйцэтгэл /2018 оны 9 сар сарын 31/

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2018 он					
		Анх батлагдсан	Төсөвт зохицуулалт хийсэн	9-р сарын төсөв /өссөн/	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Хэтрэлт хэмнэлт
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>53947</b>	<b>59850</b>	<b>59850</b>	<b>46599</b>	<b>39528</b>	<b>85%</b>	<b>7071</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	48717	51885	51885	39310	34515	88%	4794
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39802	44204	45022	34017	29483	87%	4534
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22002	23279	24048	17692	16831	95%	861
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2438	2799	2903	2134	2018	95%	116
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5094	6223	6019	3892	3573	92%	319
Хангамж, бараа материалын зардал	1161	787	922	722	590	82%	133
Нормативт зардал	2101	2449	2193	1448	1047	72%	401
Эд хогшил, урсгал засварын зардал	589	183	441	406	319	79%	87
Томилолт, зочны зардал	179	197	197	171	107	62%	64
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	355	329	331	255	190	74%	66
Бараа үйлчилгээний бусад зардал	5883	7958	7968	7296	4808	66%	2488
ТАТААС	35	38	38	31	27	86%	4
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	9	12	12	9	5	52%	4

Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	26	26	26	22	22	100%	0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8881</b>	<b>7643</b>	<b>6825</b>	5262	<b>5006</b>	<b>95%</b>	<b>256</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	299	8	8	6	6	89%	1
Бусад урсгал шилжүүлэг	8582	7635	6817	5256	5000	95%	255
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4300</b>	<b>5121</b>	<b>5121</b>	4755	<b>3848</b>	<b>81%</b>	<b>907</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>930</b>	<b>2844</b>	<b>2844</b>	2534	<b>1165</b>	<b>46%</b>	<b>1369</b>

Төсөвт өөрчлөлт хийх шаардлагагүй хэтэрсэн зардал байхгүй байхад аймгийн Засаг даргын А/558 тоот захирамжаар Сангийн сайдын 2018 оны 220 тоот тушаалыг үндэслэн аймгийн төсөвт зохицуулалт хийж урсгал шилжүүлэгээс 818.0, хангамж бараа материалын зардлаас 135.0 төгрөг хассан, норматив зардал 256.0, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 204.0, сая төгрөг хассан, цалийн хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 769.0, ажил олгогчоос төлөх шимтгэл 104.0, эд хогшил урсгал засварын зардлыг 258.0, бараа үйлчилгээний бусад зардлыг 10.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна. УИХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын төсөв зхирагч нарт хүргүүлсэн Засгийн газрын чиглэлийн төсвийн урсгал зардлын 1.2 дахь заалтын “в” дэх “тавилга шинээр худалдан авахгүй байх” гэсэн заалтыг баримталж ажиллаагүй зөрчсөн байна.

Тайлант хугацаанд 14 сум, 11 байгууллага 296.9 сая төгрөгөөр буюу 5 хувиар зардал хэтрүүлснийг хүснэгтээр харуулав.

### Төсвийн хэтрэлт

/сая.төг/

№	Байгууллагын нэрс	Батлагдсан төсөв	9 сар төсөв	9 сар гүйцэтгэл	Хэтрэлт	Хувь
1	Баян-Агт	44.9	30.2	30.8	0.6	102%
2	Баяннуур	24.0	16.2	22.0	5.8	136%
3	Булган	2,287.7	1,673.8	1,749.6	75.9	105%
4	Бүрэгхангай	201.6	132.9	138.8	5.9	104%
5	Гурванбулаг	58.0	42.0	45.1	3.1	107%
6	Дашинчилэн	5.8	4.3	4.9	0.7	116%
7	Могод	261.9	183.8	184.8	1.1	101%
8	Рашаант	511.4	363.6	373.3	9.6	103%
9	Сайхан	0.0	0.0	0.1	0.0	102%
10	Сэлэнгэ	4.8	3.9	4.3	0.4	109%
11	Хангал	0.2	0.1	0.2	0.1	182%
12	Хишиг-Өндөр	62.0	28.0	28.4	0.4	101%
13	Хутаг-Өндөр	118.7	89.2	91.3	2.1	102%
14	Хялганат	13.4	10.9	14.1	3.2	130%
15	ИТХ	7.0	5.3	5.5	0.3	105%
16	БОАЖГ	287.5	214.9	230.6	15.7	107%
17	Хүүхдийн сувилал	11.4	9.5	12.6	3.1	132%
18	СХАА	5.5	4.5	6.0	1.6	135%
19	ОНӨГ	8.2	5.9	8.1	2.3	139%
20	ГХБХБГ	32.4	24.0	30.2	6.2	126%
21	Музей	0.7	0.6	0.6	0.0	102%
22	Номын сан	0.2	0.2	0.3	0.1	144%
23	Соёлын төв	28.1	21.6	28.4	6.8	131%
24	БТСГ	49.4	36.0	40.2	4.2	112%

25	ГБХЗХГ	134.0	89.2	92.1	2.9	103%
	НИЙТ	8,071.1	5,817.7	6,114.7	296.9	105%

Төсвийн нийт дүнгээр хэтрэлт үүссэн зарцуулалт байхгүй ч төсөвт 14 сум 11 байгууллагат цалин, гэрэл цахилгаан, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбооны зардал зэрэг нийтлэг зардал хэтэрсэнг бүлэг дотор шилжүүлэн зарцуулжээ. Төсвийг оновчтой, тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүйгээс зардлын ангилалд хэтрэлт үүссэн байна. Тухайлбал:

Бүрэгхангай сумын ЗДТГ гэрээт ажилтан илүү авч ажиллуулсан, сургуулийн дотуур байрны хүүхдийн тоо нэмэгдсэнтэй холбогдож урсгал болон тогтмол зардлууд нэмэгдэж гарснаас цахилгааны зардал хэтэрч усны зардлаас шилжүүлж зардал хооронд гүйлгэж байна.

Дашинчилэн сумын ЗДТГ гэрэл цахилгааны зардлыг багаар тооцоолж хэтрүүлсэн,

Хутаг-Өндөр сумын ЗДТГ зардлын ангилал андуурч гүйлгээ хийсэн байна.

**3.2.**Тайлант онд 128 төрлийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулахаас Орон нутгийн өмчийн газрын төлөвлөгөөнд 80 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, нээлттэй тендэр 25, худалдан авах 41, зөвлөх үйлчилгээ 11, шууд худалдан авах 3-н арга хэмжээг зохион байгуулжээ.

Хэрэгжсэн байдлыг авч үзвэл гэрээ байгуулах эрх олгосон 60, үнэлгээ хийгдэж байгаа 1, зарлагдаагүй 1, хүлээгдэж байгаа 1, эрх шилжсэн 15, техник эдийн засгийн үнэлгээний зураг төсөв боловсруулах ажил 2 байна.

Хийж гүйцэтгэсэн төсөл, хөтөлбөр арга хэмжээнээс түүвэрлэн шалгаж үзэхэд хамтран ажиллах гэрээний ажил дуусгах хугацаандаа бараа, ажил, үйчилгээг хугацаа хэтрүүлж хийсэн, комисст хүлээлгэж өгөөгүй ажлуудыг хүснэгтээр харуулав.

/сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал	Батлаг дсан төсөв	Гэрээ ний дүн	Гүйцэтгэгч компани	Ажил дуусах хугацаа	Ажил дууссан хугацаа	Олгосон санхүүжилт	Хувь
1	Булган сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажил	491.3	491.2	"Сэлэнгэ есөн эрдэнэ" ХХК	2017.10.31	2018.07.22	480.9	97.9%
2	Аймгийн Музейн үзмэр дэглэлт	32.3	30.8	Монголын үндэсний музей	2018.06.15	2018.07.20	30.4	98.8%
3	Аймгийн баяр наадмын талбайг шинэчлэн засварлах	252.8	235.9	"Мөнх аригу трейд" ХХК	2018.06-15	Комисст өгөөгүй	194.1	82.3%
4	Булган сумын төвийн гэрэлтүүлгийн өргөтгөл, шинэчлэлийн ажил	477.1	443.3	"Орконтех" ХХК, "Виртуалсофт" ХХК	2018.06.19	2018.07.03	436.0	98.4%
5	Булган сумын 3 дугаар багийн А-Б хэсгийн хоорондох 0,55 км хатуу хучилттай авто зам	322.3	322.3	"Булган АЗЗА" ТӨХК	2018.06.03	Комисст өгөөгүй	282.1	87.5%

6	Аймгийн ЗДТГ-ын суудлын автомашин	50.0	50.00	Хувь хүн	2018.05.12	Комисст өгөөгүй	50.00	100%
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны яаралтай тусламжийн иж бүрдэл тоног төхөөрөмж	5.0	5.00	"Эмийн багваахай" ХХК	2018.06.15	Комисст өгөөгүй	5.00	100%
8	Булган сумын 6 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг нь сайжруулах	53.0	51.88	"Элэг бүс" ХХК	2018.06.15	2018.07.24	49.41	95%
9	Булган сумын 22 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг нь сайжруулах	79.0	67.65	"Цонхот" ХХК	2018.06.15	2018.07.24	65.02	96%
10	2017 онд хэрэгжсэн барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын дутуу санхүүжилт, 2018 онд хэрэгжүүлэх барилга байгууламж ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажил	197.7	103.01	"Нарлаг хөхий" ХХК, "ЦНТ" ХХК, "Гидросооруже ние" ХХК, "Барнаб" ХХК, "Би би кэй эйч" ХХК, "Чулуутын багш" ХХК,		Комисст өгөөгүй	103.01	100%
11	Сургуулийн дотуур байрны их засвар /Гурванбулаг сум/	124.3	121.62	"Баян өндөр булаг" ХХК	2018.07.17	2018.08.28	116.75	96%
12	Сэлэнгэ мөрний төмөр бетон гүүрийн засвар /Хангал сумын Хялганат тосгон/	77.0	76.21	"ЭЛ ЭЛ БИ АР" ХХК	2018.06.15	2018.08.19	73.63	97%
13	Аймгийн Музейн барилгын их засвар	72.0	71.47	"Хурмастын хүлэг" ХХК	2018.05.11	2018.07.18	69.75	98%
14	Дулааны станцыг ашиглалтад оруулахтай холбогдуулан Ус дулаан дамжуулах төвийн II хэлхээг холбох болон цахилгаан хангамжийг шийдвэрлэх	100.0	98.02	"Бүлээн оргил" ХХК	2018.08.27	Комисст өгөөгүй	86.47	88%
15	Аялал жуулчлалын цогцолбор байгуулах /Булган сум/	250,0	241.9	"Модерн хас" ХХК	2018.07.02	Комисст өгөөгүй	208.6	86%
16	Зүрх хүзүүний гарам гатлах онгоц тавих	110.0	108.6	"Эл эл би ар" ХХК	2018.07.05	Комисст өгөөгүй	83.2	77%

Ажил үйлчилгээг хийж байгаа боловч комисст хүлээлгэж өгөөгүй, хийж гүйцэтгэх хугацаанаас хэтрүүлж байгаа шалтгаан нь тодорхой шалтгаан байхгүй, гэрээний гүйцэтгэлийг гаргаж өгдөггүй, захиалагч нь хяналт тавьж ажилладаггүй зэргээс шалтгаалсан байна.

ТБОНӨХБАУХА тухай хуулийн дагуу нээлттэй тендер сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг шалгаж үзэхэд энэ хуулийн 30.1-т “дараах тохиолдолд бүх тендерээс татгалзана”, 30.4.1-т “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах” гэсэн заалтыг зөрчин шууд гэрээ байгуулан бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан байна.

Тухайлбал:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаас эрх шилжүүлэн Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газар LEXUS 470 маркийн авто машиныг 50.0 сая төгрөгөөр,
- Булган сумын 6 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг нь сайжруулах 49.4 сая төгрөг,
- Цаг уурын ажиглалтын талбайг томсгож, цахилгаан татах ажил 23.9 сая төгрөгөөр “Нүнжигт өргөө” ХХК-д гэрээний хуваарийн дүнгээс илүү санхүүжилт олгосон, ажлыг хугацаа хэтрүүлж хийсэн,
- Аймгийн Засаг даргын тамгын газрын суудлын авто машин худалдан авахад 1 удаа тендер зарлаад материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулах санал хүргүүлсэн, гэрээнд 53.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах захирамжаар 53.4 сая, 3.4 сая төгрөг ЗДТГ-аас гаргах, хүлээж авсан акт, хурлын тэмдэглэл байхгүй ч хүлээж авсан, одоо ашиглаж байна.

Аймгийн 80 жилийн ойд зориулж байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр аймгийн байгаль, түүх, соёлын аялал жуулчлалыг сурталчлах /альбом гаргах, зургийн цомог / ажлыг 27.2 сая төгрөгөөр “Эд маркет” ХХК хийхдээ шууд гэрээ байгуулж Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.2 дугаар заалтуудыг бүхэлд нь зөрчиж сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан,

Байгаль орчны бодлого, статистик мэдээллийн ном хэвлүүлэх ажлыг 15.0 сая төгрөгөөр “Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв ТББ” хийхдээ зориулалт бус зарцуулж ажил хүлээлцсэн актанд хүлээлцсэн номны тоо ширхэг тусгагдаагүй,

Булган сумын үерийн сувгийн даланг шинэчлэн засварлах ажлыг “Энх шилтгээн” ХХК 76.3 сая төгрөгөөр хийхдээ шууд гэрээ байгуулж гэрээний дагуу ажлыг хийж гүйцэтгээгүй хугацаа хэтрүүлж ажлыг хийсэн байна.

Иймд ажлын хариуцлага алдсан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах хугацаатай албан тоот хүргүүлэхээр боллоо.

## Төрийн Аудитын газар

### Бүлэг 4

***ИТХ-аар батлагдсан зарим хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тооны үзүүлэлтийг үнэлж дүгнэх боломжгүй байна. Хобогдох журмын дагуу хөтөлбөр арга хэмжээнд эхний хагас жилийн байдлаар тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэгджээ.***

**4.1.** Аймгийн ИТХ-ын дарга 3, аймгийн Засаг дарга 11, Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх 7 нийт 21 хөтөлбөр арга хэмжээ хийж гүйцэтгэхээр төлөвлөжээ. Зарим хөтөлбөр арга хэмжээг чанарын болон тоон үзүүлэлтээр үнэлж дүгнэхэд хүндрэлтэй буюу үнэлэгдэхүйц бус байна. Иймд тоон дүнгээр үнэлэгдэх хөтөлбөр арга хэмжээний биелэлт 09 дүгээр сарын байдлаар



77.9 хувийн дундаж биелэлттэй байна. Биелэлтийг тооцоолохдоо хүрэх үр дүнгийн гүйцэтгэлд үндэслэн тооцохдоо зарим зорилтот түвшинд нэгээс дээш үзүүлэлт хамруулсанг дундаж биелэлтийг тооцон тухайн зорилтот түвшний биелэлтийн хувийг тооцож нийт дундаж гүйцэтгэлийг гаргасан болно. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/

Цаглабарт хугацааны дөрөвний гурав буюу 75 хувийн гүйцэтгэлийн хугацаанд ТЕЗ-ч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүн 80 орчим хувийн биелэлттэй байгаа нь зохих түвшинд хүрч ажиллажээ.

**4.2.** Тайлант онд нийт 128 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ 10395.0 сая төгрөгөөр санхүүжиж хийгдэхээс одоогийн байдлаар 101 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ 7030.0 сая төгрөгөөр хийгдэж 68 хувийн гүйцэтгэлтэй байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулвал

/сая.төг/

Төсөл, хөтөлбөр, арга хэмжээ	Баталсан		Гүйцэтгэл		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	22	2713	22	2414	89%
Орон нутгийн хөгжлийн сан	17	1448	11	735	51%
Авто замын сан	10	392	10	278	71%
Байгаль хамгаалах сан	75	4641	54	2528	54%
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	4	1202	4	1075	89%
<b>НИЙТ</b>	<b>128</b>	<b>10395</b>	<b>101</b>	<b>7030</b>	<b>68%</b>

Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/288 тоот захирамжаар 10-н төрлийн гэрээгээр гүйцэтгэх нэмэлт ажлыг 155.2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Хүснэгтээр харуулвал:

/сая.төг/

№	Хийгдэж буй ажил	Нэмэлтээр хийх ажил	Нэмэлт гэрээний дүн	Гүйцэтгэгч
1	Спортын хорооны зүүн урд талын уулзвараас нэгдсэн эмнэлгийн баруун хойд талын уулзвар 0.453 км хатуу хучилттай авто зам барих	Зүүнтүрүүний 1.2 км авто замыг засах	40.0	"Булган АЗЗА" ТӨХК
2	Булган сумын 3 дугаар багийн А-Б хэсгийн хооронд 0.55 км хатуу хучилттай авто зам			
3	Аймгийн баяр наадмын талбайг шинэчлэн засварлах	Сур, шагайн талбай байгуулах, орчныг тохижуулах	30.5	"Мөнх Аригу трейд" ХХК
4	Булган сумын гэрэлтүүлгийн өргөтгөл шинэчлэлийн ажил	4-н замын уулзвараас Онцгой байдлын газар хүртэл гэрэлт гудамж байгуулах	33.8	"Виртуал софт" ХХК
5	Булган сумын гэрэлтүүлгийн өргөтгөл шинэчлэлийн ажил /3 дугаар багц/	Нэгдсэн эмнэлгээс "Ник-Петровис" ШТС хүртэл авто зам дагуу гэрэлтүүлэг	19.4	"Оркен тех" ХХК
6	Аялал жуулчлалын цогцолбор барих	Нарны эрчим хүчний гэрэлтүүлэг тавих	8.0	"Модер Хас" ХХК

7	Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохжилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хийж гүйцэтгэх	Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа будах , 2 ширэг саравч хийх	5.6	"Ай И Би" ХХК, "Баян-Өндөр Булаг" ХХК
8	Булган сумын 22 дугаар байрны орчин, нөхцөл, өнгө үзэмжийг сайжруулах	22 дугаар байрнаас соёлын төв хүртэл явган зам барих	8.8	"Цонхот" ХХК
9	9 дүгээр байр, хуучин халуун ус, Хүний хөгжлийн төв, МСҮТ-ийн зогсоол	АЗДТГ-ын баруун талын авто зогсоолыг өргөтгөх	8.6	"Оркен тех" ХХК
10	Музейн зсвар	Дотор цахилгааны монтаж шинэчлэх	0.5	"Хурмастын хүлэг" ХХК
<b>НИЙТ</b>			155.2	

Дээрхи хүснэгтээр харуулсан нэмэлт ажлын эхний 4 ажил болох нийт 123.7 сая төгрөгийн өртөгөөр хийгдсэн ажил нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.1.4-т заасан “нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол” гэсэн заалтыг зөрчжээ.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 873.7 сая төгрөгөөр баталж тайлант хугацаанд 127 арга хэмжээнд 825.6 сая төгрөг зарцуулжээ. Эхний 09 сарын өссөн дүнгээр 01-08 сард ирсэн зочид төлөөлөгч, ГОК-ын удирдлагуудыг хүлээн авах зардалд 27.7, аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн зочид төлөөлөгчийн буудал, гарын бэлэг, хүлээн авалтанд 47.0 нийт 74.7 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтыг үндэслэн зарцуулалт хийсэн нь Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7.2 дахь заалтыг үндэслэл болгож ажиллаагүй байна.

Тайлант онд малын гоц халдварт өвчин болох “Шүлхий” өвчин гарч аймаг, сумдын Засаг дарга бүрэн эрхийн хүрээнд тус өвчнийг таслах зогсоох арга хэмжээ авч ажилласан. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шүлхий өвчинтэй тэмцэхэд зориулж 19.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/394 тоот захирамжаар аймгийн 80 жилийн ойн баяр наадмын нээлт, хаалтын үйл ажиллагаа, үдшийн цэнгүүнийг зохион байгуулахад зориулж 200.0 сая төгрөгийг “Уран тогоо” нэгдлийн 5111457466 тоот дансанд 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдөр 100.0, 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдөр 100.0 сая төгрөгийг 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн ажил гүйцэтгэх гэрээг үндэслэн олгосон, гүйлгээний баримтанд Засаг даргын захирамж, гэрээнээс өөр ямар нэгэн баримт байхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/287 тоот захирамжаар МСҮТийн дотуур байрны зүүн талд байрлалтай иргэн Ц.Батжаргал, Г.Эрдэнэ, Д.Уламбаяр, А.Ганболд нарын эзэмшлийн 741 м.кв газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авахаар 60.0 сая төгрөгийн гэрээ байгуулж 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдөр А.Ганболдолд 5.0 сая төгрөг, 2018 оны 07 дугаар сарын

4-ний өдөр 25.0, 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/579 тоот захирамжаар Ц.Батжаргалд 10.0 төгөргийг тус тус олгоходоо газрын гэрчилгээ болон бусад холбогдох материалуудыг авч хавсаргаагүй байна.

Аймгийн ОНХС-аас цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны дуудлагын фургон автомашин /тусгай тоноглол бүхий/ авсан нь ОНХС-гийн хөрөнгийн зарцуулах журмын 4.4 дэхь “аймаг, нийслэл, сум дүүргийн удирдлагын хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” заалтыг зөрчсөн байна.

Аймгийн Засан даргын Тамгын газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Б/10 тоот тушаалаар аймгийн ЗДТГ-ын ажил олгогчоос олгох тусламж, урамшууллын данснаас албан хаагчдад орон байраар хангах, орон сууцны дэмжлэг 60.0 сая төгрөг батлаж 9-р сарын байдлаар 6-н албан хаагчид 47.5 сая төгрөгийг 2018 оны төсөвт суулгаагүй олгосон байна. Өмнөх онд 4-н албан хаагчид 40.0 сая төгрөг олгож аудитаас төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 42.7 дэхь “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлхийг хориглоно” гэснийг мөрдөж ажиллаагүй, ажилтан албан хаагчдад олгож байгаа орон сууцны хөнгөлөлтийг аймгийн ИТХ-аар батлуулж байх, байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулан төсөв, жилд олгох хүний тоог тодорхой тусгуулах гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Аймгийн ЗДТГ-ын удирдлагууд төсөв боловсруулж түүнийг захиран зарцуулдаг давуу байдлаа ашиглаж зөвхөн аймгийн ЗДТГ-ын албан хаагчдад 2014-2018 онд нийт 22 хүнд 215.0 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлт олгожээ. Орон нутгийн төсөвт байгууллагуудад үр дүтээлтэй олон жил ажилласан албан хаагчийн амьдрал ахуйг харгалзан үзэж олгох ёстой.

Хишиг-Өндөр сум нь Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулах журмын 5.1-т “Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно” гэж заасныг мөрдөөгүй 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдөр сумын камержуулалтанд зориулж 444.5 мянган төгрөг зарцуулсан байна.

**4.3.Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дагуу Хөгжлийн хөтөч хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний жил жилийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлын хэсэг Засаг даргын захирамжаар томилогдон ажиллаж Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А/280 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг баримтлан дотоод хяналт тавин ажилласан байна.**

Хяналт шинжилгээний үнэлгээний хүснэгт

Үзүүлэлт	Үүнээс																		
	Бүгд	1. Хүн нийгмийн хөгжил					Бүгд	2. Эдийн засгийн тогтвортой хөгжил						Бүгд	3. Дэд бүтцийн хөгжил			Бүгд	5. Хууль эрх зүйн бодлого
		1.1. Боловсрол	1.2. Ажил	1.3. Цэвэр ус	1.4. Эдийн засгийн өсөлт	1.5. Хүн амын өсөлт		2.1. Эдийн засгийн өсөлт	2.2. Үйлдвэр	2.3. Үйлдвэр	2.4. Байгалийн баялаг	2.5. Агаар	2.6. Туслах		3.1. Зам тээвэр	3.2. Ажил	3.3. Мэдээл		

Хяналтад авсан нийт зорилтын тоо	70	28	5	8	4	4	7	21	1	5	2	7	2	4	7	3	1	1	2	8	6	
Хяналтад авсан нийт арга хэмжээний тоо	340	97	27	0	13	18	39	130	1	38	21	39	17	14	34	12	6	4	12	36	43	
Үүнээс	Үр дүнтэй 100 /90-100/	71	24	8	0	3	6	7	25	0	2	7	12	4	0	12	3	0	4	5	5	5
	Тодорхой үр дүнд хүрсэн 70 /60-89/	166	58	16	0	10	11	21	54	1	10	9	18	3	13	11	4	3	0	4	15	28
	Эрчимжүүлэх шаардлагатай 40 /31-59/	83	15	3	0	0	1	11	41	0	21	5	5	9	1	6	2	2	0	2	16	5
	Үр дүнгүй 0 /0-30/	15	0	0	0	0	0	0	7	0	3	0	3	1	0	3	1	1	0	1	0	5
	Үнэлэх боломжгүй	5	0	0	0	0	0	0	3	0	2	0	1	0	0	2	2	0	0	0	0	0
<b>Хувь</b>	<b>66</b>	<b>73</b>	<b>76</b>	<b>0</b>	<b>77</b>	<b>78</b>	<b>67</b>	<b>62</b>	<b>70</b>	<b>48</b>	<b>73</b>	<b>70</b>	<b>57</b>	<b>68</b>	<b>69</b>	<b>66</b>	<b>48</b>	<b>100</b>	<b>72</b>	<b>61</b>	<b>62</b>	

Дотоод хяналтыг хагас жил болон жилийн эцэст хийж аймгийн ИТХ-д танилцуулдаг, 2018 оны эхний хагас жилээр хяналтад авсан зорилтын тоо 70, хяналтад авсан арга хэмжээний тоо 379-ийг авч дүгнэхэд 65.8 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэж байна.

## ДҮГНЭЛТ:

**Булган аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- Орлогыг төлөвлөхдөө гол төлөв өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн боловсруулдаг,
- Зарцуулалтыг УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын дагуу төсөв захирагч нарт хүргүүлсэн Засгийн газрын чиглэлийн 1.2 дахь заалтын “в.д”-д заасантай нийцээгүй төсөл хөтөлбөрийг төлөвлөн баталсан,
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу холбогдох эх үүсвэрийн дүнгийн Байгалийн нөөцийг нөхөн сэргээх хувь хэмжээгээр 56-413.6 хувиар давсан дүнгээр нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулахаар баталсан,
- Усны нөхөн сэргээлтэнд зарцуулагдах хувь хэмжээ 24.2 хувиар дутуу байгаа нь аймаг, орон нутгийн онцлог, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс усны төлбөрт их хэмжээний мөнгө орж ирдэг зэрэг онцлогоос шалтгаалан ус, рашаан ашигласны төлбөрийг хуульд заасны дагуу усны чиглэлээр зарцуулах боломж, бодит нөхцөлгүй тул аймгийн байгаль хамгаалах санд төвлөрсөн хөрөнгийг багц төсөл, арга хэмжээнд жилийн эцэст төсөв батлахдаа мэргэжлийн байгууллага, сум, агентлагуудын санал, судалгаа, тооцоог үндэслэн аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан хуваарийн дагуу зарцуулж байна,

- Өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөдөг ч Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслээгүй төлөвлөснөөс 6-8 дахин давж биелэсэн,
- Нийт дүнгээр ус, шараан ашигласны төлбөр давж биелэсэн ч төлөвлөгөөнд багтсан комданиудын усны орлого бүрэн төвлөрөөгүй, төлөвлөөнд тусгагдаагүй аж ахуйн нэгжээс нийт 38.9 сая төгрөг төвлөрсөн,
- Аймгийн нийт дүнгээр таван нэр төрлийн зардал 18.1-46.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төсөвт байгууллагууд бүгд аудитын баталгаажуулалтын төлбөрийг төлөвлөдөг ч ихэнх байгууллага түүвэрт хамрагдаж төлбөр төлөөгүйгээс хэмнэгдсэн бол бусад зарцуулалт жилдээ зарцуулахаар хүлээгдэж байгаа нь нэг удаагийн биш зардлын хуваарийг оновчтой төлөвлөөгүйгээс хэмнэлт үүссэн,
- Төсвийн төсөл боловсруулахдаа тооцоо судалгааг нарийн хийгээгүй, мэдээлэл дутмагаас орлого бүрдэх нөөцийг бүрэн дайчлаагүй, Төрийн аудитын газраас хийсэн нэмэлт тооцоо судалгаанд үндэслэн 924.8 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх санал хүргүүлсний 54.9 хувийг ИТХ-аар дэмжин баталсан,
- Хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт орлого төлөвлөлтөөс 5.7 хувиар буюу 1173.1 сая төгрөгөөр нэмж биелэхээр байгаа ч цөөн нэр төрлийн өндөр дүнтэй орлого давж, зарим нэр төрлийн орлого тасрах хандлагатай байна,
- Эхний 09-н сарын өссөн дүнгээр авлага 2.9, өглөг 341.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй,
- ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу нээлттэй тендер сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг шалгаж үзэхэд энэ хуулийн 30.1-т “дараах тохиолдолд бүх тендерээс татгалзана”, 30.4.1-т “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах” гэсэн заалтыг зөрчин шууд гэрээ байгуулан бараа, ажил, үйлчилгээг худалдан авдаг,
- Төсвийг оновчтой, тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүйгээс зардлын ангилалд хэтрэлт үүссэн байна,
- Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын журмыг мөрдөж ажилладаггүй анхан шатны баримтгүй гүйлгээ хийдэг,
- ТЕЗ-ч нарын хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн биелэлт 80 орчим хувийн гүйцэтгэлтэй,
- Бараа, ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэсний дараа комисст хүлээлгэж өгдөггүй, комисс хүлээж авдаггүй, гэрээний хугацаа хэтрүүлж ажил хийдэг зэрэг алдаа зөрчил илэрсэнд цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

## **ЗӨВЛӨМЖ:**

**Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:**

### **ТЕЗ буюу Засаг дарга, ЗДТГ-ын СТСХ-ийн дарга нарм:**

1. Орлого зардалыг төлөвлөхдөө өмнөх онуудын гүйцэтгэлд голчлон анхаарч тооцооллыг хийлгүй бусад мэргэжлийн байгууллагуудаас шаардагдах мэдээ, судалгаанд үндэслэж тооцоолол хийн нөөц боломжийг бүрэн

- байчилж, зарцуулалтыг холбогдох хууль, эрх зүйн акттай бүрэн нийцсэн төсөл хөтөлбөрийг төлөвлөн батлах,*
- 2. Орлого бүрдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хуулийн дагуу холбогдох байгууллагуудад шаарддаг байх,*
  - 3. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.1, 30.4.1, 34.1.4 дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах,*
  - 4. Төсвийг оновчтой тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөх,*
  - 5. Бараа ажил үйлчилгээг хийж гүйцэтгэсний дараа цаг хугацаанд нь комисс томилож хүлээн авч байх,*
  - 6. Авлага, өглөг нэмж үүсгэхгүй байхад анхаарч үүссэн авлага, өглөгийг барагуулж ажиллах.*

**Мэдэгдэл:**

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан арга хэмжээ авч ажиллан 2018 оны 12 дугаар сарын 25-ны дотор хариу ирүүлэхийг мэдэгдэе.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

АУДИТОР

А.СУВДАА

Х.БАТТУЛГА

ТЕЗ БУЮУ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.БАТЦОГТ





